

Н.ЧОМСКИЙН ЖИШИГ ОНОЛЫН ХҮРЭЭНД ДЭВШҮҮЛСЭН ӨГҮҮЛБЭРИЙН ГҮН БҮТЭЦ ГЭХ ОЙЛГОЛТ ЛОГИК ХЭЛБЭР МӨН ҮҮ?

М.Отгонбаяр /доктор (Ph.D), профессор/
С.Бүжинлхам /магистр/
МУИС, Философи, шашин судлалын тэнхим

Түлхүүр үгс: квантор, утгазүй, үүсгүүр хэлзүй, парافраз

Товч утга: Хэл шинжлэл философи хоёр хоорондоо холбоотой юу? Тийм бол хэрхэн илрэх бололцоотой вэ? Хэл шинжээч болон философичийн бүтээл нь бие биендээ хэрхэн дэм болох вэ? гэх асуултуудыг шийдэхэд сонгодог жишээ болж чадах төлөөлөл бол Н.Чомскийн бүтээлүүд юм. Н.Чомский үүсгүүр хэлзүйн жишиг онолын хүрээнд гүн бүтэц нь өгүүлбэрийн утгыг илэрхийлж буй бол өнгөн бүтэц нь түүний физик шинж талыг төлөөлдөг гэж үзсэн. Иймээс өнгөн бүтэц нь өгүүлбэрийн “жинхэнэ” прагматик хэлбэр гэсэн үг юм. Нөгөө талд гүн бүтэц нь илүү хийсвэр шинжтэй бөгөөд хэрэглэгчийн оюун/тархинд төрөлхөөс байдаг байна. Гүн бүтцийн түвшинд үг нь өгүүлэхүүн, өгүүлэгдэхүүн, тусагдахууны үүргээ олж авдаг. Эдгээр тайлбараас харахад гүн бүтэц бодомжтой төстэй болж таарж байгаа юм. Учир нь бодомж бүр өгүүлбэр байх ёстой ч өгүүлбэр бүр бодомж байх албагүй байдаг билээ. Иймээс гүн бүтэц логикийн хэлбэр байх бололцоотой эсэхийг эрэлхийллээ.

Хэл шинжлэл философи хоёр хоорондоо холбоотой юу? Тийм бол хэрхэн илрэх бололцоотой вэ? гэх асуултанд логикийг талбар болгон авч тайлбарлахыг зорьсон болно. Холбогдох асуудлыг шийдэхэд сонгодог жишээ болж чадах төлөөлөл бол Н.Чомскийн бүтээлүүд юм. Учир нь Н.Чомский хэл шинжээч хэдий ч түүний дэвшүүлсэн онол нь хэл шинжлэл, оюун санааны философи, болон логикт томоохон хувь нэмэр оруулсан билээ. Иймээс ч түүнийг хэл шинжээч гэхийн хамт хэл шинжлэлийн философич хэмээн үздэг. Энэ талаар Ж.МакГилврэй “Чомскийн талаарх Кэмбрижийн лавлах” хэмээх бүтээлийн өмнөтгөлд “Чомский нь эрдэмтний зэрэгцээ философич бөгөөд түүний шинжлэх ухааны ажлын үргэлжлэл

нь философийн бүтээлүүд байдаг”¹ хэмээн бичсэн байдаг.

Эмпирик баримтанд тулгуурлан судалгаагаа явуулах, хэл болон хүний оюуны бусад үйл ажиллагаанд гадаад орчинтойгоо харилцаж суралцсан үр дүн чухал нөлөөтэй гэх хандлага хорьдугаар зууны дунд үед хүмүүнлэгийн ухаанд ноёрхож байлаа. Харин Н.Чомский хэл шинжлэлийн судалгаандаа математик болон логик арга ашигласны үр дүнд хэлний дүрмийн цогц нь хүнд төрөлхөөс байдаг гэдэг дүгнэлтэнд хүрсэн нь судлаачдыг хэл, оюун санааны тухай асуудлыг дахин нягталж харахад хүргэжээ. Түүний “Коперникийн хувьсгал”-ыг авч

¹ J.McGilvray. (ed). The Cambridge Companion to Chomsky. Cambridge University Press, 2005. p 1

ирсэн бүтээл болох “Өгүүлбэрзүйн бүтэц” номын талаар Ж.Сёрл: “Чомскийн бүтээл нь Кэйнс эсвэл Фрейдийн бүтээлүүдтэй харьцуулахуйц хүрээг хамарсан, орчин үеийн хамгийн содон оюуны ололт амжилтуудын нэг юм. Энэ нь хэл шинжлэлд хувьсал хийхээс гадна үүсгүүр хэлзүй (generative grammar) гэх шинэ салбарыг бүтээж улмаар философи, сэтгэл судлал гэсэн хоёр салбарт хувьсгалч нөлөө үзүүлсэн.”² хэмээн дүгнэсэн байдаг. Энд дурдагдсан үүсгүүр хэлзүйн онол нь хэд хэдэн хувьслыг дамжин өнөөгийн төрхөө олсон байна. Эдгээрийг хүснэгтээр багцлан үзүүлбэл:

“Өгүүлбэрзүйн онолын асуудлууд” зохиолд “мэдэхүй (ярилцагч сонсогчийн хэлний тухай мэдлэг) болон гүйцэтгэхүй (тодорхой нөхцөлд хэлийг бодитоор ашиглах явдал)”³ гэх ойлголтыг ялгаж улмаар бодит байдал дээр тухайн хэлийг эзэмшсэн хүн нь ярилцах явцдаа өөрийн хэлний мэдлэгийг бүрэн дүүрэн зөв зүйтэй илэрхийлж чаддаггүй. Гэтэл “техникийн утгаараа хэл шинжлэлийн онол авир үйлдлийн цаана буй оюуны (mental) бодит байдлыг нээхэд анхаардаг тул менталист шинжтэй”⁴ тиймээс хэл шинжээчид тухайн хэлийг эзэмшигчийн “мэдэхүй”-д төвлөрөх нь зүйтэй гэж үзсэн байна.

Үүсгүүр хэлзүйн онолын загвар*	Гол бүтээл
Хувиргал-үүсгүүр хэлзүй	“Өгүүлбэрзүйн бүтэц” [Syntactic structures (1957)]
Жишиг онол	“Өгүүлбэрзүйн онолын асуудлууд” [Aspects of the theory of syntax (1965)]
Өргөтгөсөн жишиг онол	“Нэрлэлтийн талаарх тайлбар” [Remarks on Nominalization (1970)]
Захирах ба баглах загвар (Зарчим ба хэмжигдэхүүний онол)	“Захирах болон баглалтын талаарх лекцүүд” [Lectures on Government and Binding (1981)] “Саад” [Barriers (1986)]
Минималист программ	“Минималист программ (Хэл шинжлэлийн орчин үеийн судалгаа)” [Minimalist program (Current studies in linguistics) (1995)]

(хүснэгт 1)

Уг өгүүллийн хүрээнд үүсгүүр хэлзүйн онолын бүхий л загварыг хамааруулахыг зорьсонгүй. Харин үүсгүүр хэлзүйн нэгэн загвар болох жишиг онолын хүрээнд дэвшүүлсэн өгүүлбэрийн гүн бүтэц гэх ойлголтыг логиктой холбон тайлбарлахыг оролдлоо. Уг зорилгын хүрээнд эхлээд жишиг онол гэж юу болох хийгээд гүн бүтцийн тухай тайлбарлах хэрэгтэй билээ.

Менталист шинжтэй гэдгийн учир нь үүсгүүр хэлзүй бол тухайн хэлээр ярилцагч хүнийг ямар авир үйлдэл гаргавал зохихыг заадаг загвар бус харин ч хэлийг эзэмшигч өөрийн интуицээр хэлийг зөв хэрэглэж буй тэр мэдлэгийг судалж тайлбарлахыг зорьдог аж. Тэгэхээр хэлзүйн зорилго нь тухайн хэлийг “төгс” эзэмшигчийн мэдэхүйг тайлбарлах явдал

² J. Searle. Chomsky's Revolution in Linguistics, Retrieved from The Noam Chomsky, June 29, 1972. url: <http://www.chomsky.info/onchomsky/19720629.htm>

* Сэдвийнхээ хүрээнд л хамааруулж Н.Чомскийн үзэл санаа болон бүтээлийг тусгайлан авч үзэж буйгаас бус бусад үүсгүүр хэлзүйчид болон тэдгээрийн бүтээлийг үл тоомсорлосон хэрэг биш болохыг анхаарна уу.

³ N.Chomsky. Aspects of theory of syntax. Massachusetts: MIT press, 1965. p 4

⁴ Ibid., p4

болж таарч байна. Учир нь дүрмийн дагуу бус ч гэсэн ойлгогдохуйц өгүүлбэрийг бид “гүйцэтгэхүйн” түвшинд хэлээд ойлголцоод байж чаддаг. Харин дүрмийн дагуу байна уу үгүй юу гэх асуудал мэдэхүйн түвшинд хамаарах билээ. Мэдэхүйг хэрхэн тайлбарлах вэ? гэх асуултанд Н.Чомский тухайн хэлийг төгс эзэмшигч өгүүлбэрийг хэрхэн ойлгож, бүтээж буйг судлах явдал хэмээн хариулсан аж. Учир нь бид “тодорхой” хэлзүйг буюу ялгаатай хэлийг эзэмшиж, япон, монгол, англи зэрэг хэлээр ярилцдаг хэдий ч бүхий л хэлэнд заавал байдаг, нийтлэг зүйлс байдаг агаад тэдгээрийг “түгээмэл буюу философийн хэлзүй”⁵ гэж нэрлэдэг байна. Хэл бүхэнд түгээмэл байх нэг шинж бол түүний бүтээлч тал агаад уг шинжийг өгүүлбэрээр дамжуулан тайлбарлах нь зохимжтой аж. Учир нь хэлний бүтээвэр (morpheme) болон авиалбар (phoneme) нь хэдийгээр олон тооны байлаа ч тэдгээрийг жагсаан бичих боломжтой байдаг тул тэдгээр нь төгсгөлөг. (Жишээлбэл: Монгол хэлний үйлийн хийгээд нэрийн нөхцөл тодорхой тоотой агаад тэдгээрийг “харьяалахын тийн ялгал: -ийн, -ын, -ий, -ы,” гэх мэтээр нэрлэж жагсааж болж байна.) Гэтэл бид өгүүлбэрийг тэгж жагсаан бичиж хязгаарлах боломжгүй. (Жишээлбэл: “Ээж ирэв. Ээж хөдөөнөөс ирэв. Ээж хөдөөнөөс хонь авч ирэв.” гэх мэтээр цааш дэлгэрүүлээд л байж болно.) Энэ утгаараа өгүүлбэр нь хувь хүн бүрийн хэлний тухай мэдлэгийнх нь бүтээлч талыг илэрхийлэхийн зэрэгцээ, хэлний бусад нэгжийг өөртөө агуулж байна.

⁵ Н.Чомский уг нэр томъёог Жэймс Бумтигийн [Beattie, James (1788). *The theory of language. Part I. Of the origin and general nature of speech. Part II. Of universal grammar*] бүтээлээс ишилсэн байдаг.

Улмаар Н.Чомский зорилгынхоо хүрээнд өгүүлбэрзүй, утгазүй, авиазүйн бүрэлдэхүүний тухай авч үзсэн байна. Өгүүлбэрзүйн бүрэлдэхүүн нь төгсгөлгүй олон өгүүлбэрийн дотоод формаль бүтцийг бүрэлдүүлэх бол авиазүйн бүрэлдэхүүн нь өгүүлбэрзүйн дүрмийн дагуу бий болсон өгүүлбэрийн авианы хэлбэрийг (phonetic form) тодорхойлж, утгазүйн бүрэлдэхүүн нь өгүүлбэрийн утгыг тайлбарлахтай холбогддог байна. Уг бүрэлдэхүүнүүд нь өгүүлбэрзүй гэх суурин дээр суурилах агаад эсрэгээрээ байх боломж үгүй юм. Өөрөөр хэлбэл өгүүлбэрийн утга болон авиа нь өгүүлбэрзүйн үр дүн болохоос бус өөрөө өөрсдийгөө бүрэлдүүлдэггүй аж.


Цаашилбал өгүүлбэрийн утгазүйн бүрэлдэхүүн нь тухайн өгүүлбэрийн гүн бүтэцтэй холбогдох аж. Жишээлбэл “John is easy to please. John is eager to please” (Жоны таалалд нийцүүлэх хялбар. Жон (бусдын) таалалд нийцүүлэхийг хүсдэг.) гэх хоёр өгүүлбэр нь өгүүлбэрзүйн бүтцийн хувьд адилхан байгаа хэдий ч эхний өгүүлбэрт Жон нь тухайн үйлдлийг хүлээн авч буй нэгэн байхад удаах өгүүлбэрт тэрээр хэн нэгийг таалалд нийцэхийг зоригч болж таарч байна. Иймээс энэ хоёр өгүүлбэр нь өнгөн бүтцийн хувьд ижил хэлбэртэй хэдий ч гүн бүтцийн хувьд ялгаатай бүрэлдэхүүнтэй хэмээн Н.Чомский тайлбарлажээ.

Ийнхүү утгазүйн бүрэлдэхүүнийг (semantic component) анхаарахад хүргэсэн шалтгаан нь Кац-Постал нар тухайн өгүүлбэр дэх үгийн сангийн утга нь өгүүлбэрзүйн холбооноос хамаарна гэдгийг тайлбарласнаас үүдэлтэй юм.⁶ (Жишээлбэл “Улаан алим идэв.” “Улаан

хөдөөнөөс ирэв.” гэх хоёр өгүүлбэрт аль алинд нь улаан гэх үг орсон хэдий ч эхний өгүүлбэрт улаан гэх үг тодотголын үүргээр орсон тэмдэг нэр байхад, удаах өгүүлбэрт улаан гэх үг нь өгүүлэгдэхүүний үүргээр орсон нэр үг болох нь тодорхой байна.)

Өгүүллийн маань гол асуудал болох өгүүлбэрийн гүн бүтэц нь хэлцэн бүтцийн дүрмийн дагуу бий болох бол өнгөн бүтэц нь хувиргалын дүрмүүдийн үр дүнд бүрэлддэг аж. Хэлцэн бүтэц гэдэг нь өгүүлбэр бол зүгээр л үгийн дараалал төдий биш харин хэлцүүдийн бүтцэн хамааралд оршдог гэдгийг харуулдаг. Жишээлбэл: “Дорж номоо авав.” гэх өгүүлбэр Дорж гэх нэрийн хэлц (NP-Noun phrase) *, номоо авав (VP-Verb phrase) гэх үйлийн хэлцээс бүрдэх ба үйлийн хэлц нь цааш “номоо” гэх нэрийн хэлц, “авав” гэх үйл үгээс (Verb) бүрдэж байна гэж задалж болно. Хувиргалын дүрэм нь өгүүлбэрийн гишүүдийг нэмэх (add), хасах (delete), хөдөлгөх (movement) замаар нэг хэлцэн бүтцээс ондоо бүтцэнд өгүүлбэрийг хувиргадаг аж. Чухам ямар учраас гүн бүтцэд өгүүлбэрийн утгазүй хийгээд өгүүлбэрзүйн бүрэлдэхүүн холбогдож байна вэ? гэх асуултанд Н.Чомский өгүүлбэрийн гишүүдийн тета үүрэг хэмээн хариулсан байна. Тета үүрэг гэдэг нь өгүүлбэрийн гишүүдийн үйлдэгч, хүлээн авагч, үйл явдал, зорилго зэргийг заадаг байна. Харин хувиргалын дүрэм нь өнгөн болон гүн бүтцийг хооронд нь холбох холбоосын үүргийг гүйцэтгэх

болсон байна. Дээрх санааг:



гэх схемээр илэрхийлж болох юм.

Эндээс дүгнэхэд жишиг онолд өгүүлбэрзүйгээс гадна, утга болон авианы хоорондын харилцааг шийдвэрлэх үүргийг “хэлзүйд” оноож өгсөн байна. Ийнхүү авиа болон утгын бүрэлдэхүүнийг өгүүлбэрийн илэрхийллийн ялгаатай хоёр түвшин болох гүн бүтэц болон өнгөн бүтцээр дамжуулан тайлбарласан байна. Гүн бүтэц нь тухайн өгүүлбэрийн утгын талыг “хариуцах” бол өнгөн бүтэц нь өгүүлбэрийн физик тал буюу авианы хэлбэртэй шууд хамаарна. Өөрөөр хэлбэл өнгөн бүтэц бол бидний өдөр тутам хэрэглэж буй өгүүлбэрийн “бодит” хэргэлээний хэлбэр юм. Харин гүн бүтэц нь илүү “хийсвэр шинжтэй” агаад, тухайн хэлийг эзэмшигчийн мэдэхүй буюу оюун тархинд хамааралтай аж.

“Өгүүлбэр зүйн онолын асуудлууд” зохиолдоо Н.Чомский хэлийг эзэмших үйл явцыг авч үзээд хүүхдэд хэл сурах төхөөрөмж (language acquisition device) төрөлхөөс байдаг гэсэн таамаглал дэвшүүлсэн байна. Ийм ч учраас эцэг эхчүүд дүрмийн бус, алдаатай өгүүлбэрээр ярьсан хэдий ч хүүхэд зөв “хэлзүй”-г

⁶ Jerrold J. Katz. & Paul M. Postal. *An Integrated Theory of Linguistic Descriptions. (Research Monographs.)* Cambridge, 1964 гэх номноос дэлгэрүүлэн үзнэ үү.

* Д. Цэрэнпил “phrase structure” гэх үгийг “хэлцэн бүтэц” хэмээн орчуулсан бол Э.Равдан “бүрэлдүүрбэрийн бүтэц” хэмээн буулгасан байдаг.

⁷ N. Chomsky. *Aspects of theory of syntax.* Massachusetts: MIT press, 1965. P 58

хурдан хялбархан эзэмшдэг аж. Иймд хүний хэл эзэмших чадвартай холбогдох төрөлх зарчмуудыг “түгээмэл хэлзүй” илэрхийлэх бололцоотой юм. Учир нь түгээмэл хэлзүй бол хэл бүрт байдаг ижил шинжийг агуулдаг. Өөрөөр хэлбэл хүний хэлний мэдэхүйн ихэнхи нь төрөлх байдаг агаад хаана ямар хэлийг сурснаас шалтгаалан үүн дээр нэмэгдэх мэдээлэлд бид суралцдаг байна. Уг өнцгөөс хандвал өгүүлбэрзүйн гүн бүтэц нь хүнд төрөлхөөс байдаг гэж дүгнэх боломжтой юм. ХХ зууны нэртэй философич К.Поппер хэлэнд суралцахуйн үндэс суурь нь зөвхөн хүнд л байдаг төрөлх зуршил гэж үзсэн байдагтай дээрх тайлбар тохирч байгаа юм. Тэрээр “Хүн болон амьтдад байдаг тогтсон зуршил нь тодорхой нөхцөлд, тодорхой байдлаар төрөлх шинжтэй байдаг. Тэр ч байтугай төрөлх биш олдмол байсан ч төрөлх зуршлын хувирсан дүрс юмуу дасан зохицолдооны үрээр олдсон байдаг. Жишээ нь англи эсвэл франц хэлийг эзэмших нь олдмол зуршил юм. Гэвч үүний үндэс сууринд хэлийг сурах хүний төрөлх зуршил байдаг.”⁸ хэмээн “Бие ба оюун ухааны харилцан үйлчлэлийн асуудал хийгээд мэдлэг” өгүүлэлдээ бичсэн байдаг билээ. Бид хэлний дүрмийг мэдэхгүй ч түүнийг зохистой хэрэглэж сурсан байдагтай адил логик судлаагүй хэдий ч зөв сэтгэдэг.

Энэ утгаараа уг өгүүлэлд хүний төрөлх зуршилд холбогдох ойлголтуудын огтолцолыг онцолж байгаа юм.

Үүсгүүр хэлзүйн дараагийн загвар болох “өргөтгөсөн жишиг онол” болон

⁸ К.Поппер. “Бие оюун ухаан хоёрын харилцан үйлчлэлийн асуудал хийгээд мэдлэг. Орч: М.Отгонбаяр. Эрх чөлөө ба философи.(III). Улаанбаатар, 1998. хууд 59

“захирах ба баглах загвар”-т өгүүлбэрийн “утгын талыг хариуцах” логикийн хэлбэр гэх хэлзүйн бүрэлдэхүүн хэсгийн тухай авч үзсэн байдаг. Иймээс үүсгүүр хэлзүйн хүрээнд хамаарах логикийн хэлбэр* гэх ойлголтыг философи, логикт хэрэглэдэг логик хэлбэрээс ялгаатай гэдгийг анхаарах хэрэгтэй юм. Энэ талаар Л.Т.Ф.Гамут (L.T.F.Gamut) “Логикийн хэлбэр гэх нэр томъёогоор орчин үед нэлээд ялгаатай хоёр зүйлийг (түүхийн хувьд хоорондоо хамааралгүй байж болох хэдий ч) нэрлэх болсон. Нэг талаас далаад оноос хойш үүсгүүр хэлзүйд түгээмэл хэрэглэн, судалж буй ойлголтыг нэрлэж болох юм ... Эсвэл уг нэр томъёо нь философиос гаралтай илүү хуучны ойлголтыг зааж байх ч боломжтой.”⁹ гэж бичсэн байдаг. Товчхондоо “гүн бүтэц” гэх ойлголт логикт хэрхэн уялдах тухай асуудлыг энд авч үзэх тул хоёр дахь утгаар нь “логик хэлбэр” гэх нэр томъёог ашиглах юм. Ингээд “логик хэлбэр” гэх ойлголт нь ямар утгатай болохыг тодруулъя. “Танин мэдэхүйн ухааны тухай МИТ сургуулийн нэвтэрхий толь бичиг”-т “Философичид “өгүүлбэрийн логик хэлбэр” гэдэг илэрхийллийг хэрэглэхдээ өгүүлбэрийн өнгөн хэлзүйн хэлбэрт байдаггүй хэлзүйн илэрхийллийн хорхой хүргэм шинжийг заан нэрлэдэг”¹⁰ гэсэн бол “Философийн талаарх Роутлеж нэвтэрхий толь бичигт”

⁹ L.T.F. Gamut. *Logic language and meaning: Volume 2 Intensional logic and logicagal grammar*. Chicago: University of Chicago press, 1991. p 214

*Англи хэл дээр аль аль ойлголтыг “logical form” гэж бичиж буй хэдий ч нэр томъёог будлиантуулахгүйн үүднээс үүсгүүр хэлзүй дэхь “logical form”-г “логикийн хэлбэр”, философи, логикт хамаарагдах “logical form”-г “логик хэлбэр” хэмээн ялгаатайгаар хэрэглэв.

¹⁰ J. C. Stanley (n.d.). *Logical Form, Origins of*. Retrieved from The MIT Encyclopedia of the Cognitive Sciences url: <http://ai.ato.ms/MITECS/Entry/stanley2.html>

“Төрөлх хэлэн дэх өгүүлбэрийн логик хэлбэр гэдэг нь түүний логик шинж болон бусад өгүүлбэртэй холбогдох логик холбоосыг тодорхойлдог”¹¹ гэж бичсэн байдаг байна. Дээрх хоёр ишлэлээс логик хэлбэр гэдэг нь нэгдүгээрт “хэлзүйн хэлбэр”-ээс тодорхой утгаар ялгаатай, хоёрдугаарт логик холбоос болон хувьсагчуудын тусламжтайгаар хэлний илэрхийллийг тодорхойлдог формаль бүтэц гэж дүгнэж болох юм. Гүн бүтцийн тухай ойлголт нь жишиг онолын нэг бүрэлдэхүүн хэсэг болдог тул хэлзүйд хамаарах тайлбар атал ямар шалтгаанаар уг ойлголтыг логик хэлбэртэй адилтгах болсон бэ гэх асуулт гарч ирнэ. Үүнд дараах байдлаар хариулъя.

Н.Чомский болон Ж.Пиаже нарын мэтгэлцээний талаар М.Пиателли Палмарини бичихдээ “Формаль логик болон тооцооллын дүрмүүд (computational rule) нь (яагаад ч юм) өгүүлбэрийн гүн бүтцийг тодорхойлоход оролцдог аж”¹² хэмээн дүгнэсэн байдаг.

Мөн Алессандро Ленций, Габриел Санду нар: “Логикд бараг л түүнд зориулагдсан гэж болохуйц хүний хэлний түгээмэл зарчмыг эрэлхийлэх үүрэг байдаг. Гэтэл хэл шинжлэлийн үндсэн зорилго бол түгээмэл хэлзүйг эрэлхийлэх явдал хэмээн баталсан үүсгүүр хэл шинжээчдийн хурдтай өсөлтийн явцад логикийн уг үүрэг үнэхээр чухал сорилтыг туулжээ”¹³ гэх сонирхолтой санааг

“Хорьдугаар зууны логик болон хэл шинжлэл” гэх өгүүлэлдээ бичсэн явдлыг харгалзан үзээд гүн бүтэц гэх ойлголтыг логикийн үүднээс тайлбарлах боломж бий эсэхийг судлахыг зорьсон юм.

Өгүүлбэрийн гүн бүтцийн түвшинд уг хэлцэн бүтцийн дүрэм хийгээд үгийн сангийн утгатайгаа уялдан өгүүлэхүүн, өгүүлэгдэхүүн, тусагдахуун зэрэг өөрийн тета үүргийн дагуу “байр сууриа хэрхэн олж” болохыг илэрхийлдэг болохыг дээр дурдсан. Харин хувиргалын дүрмийн дагуу өнгөн бүтэц нь бүрэлдэх бөгөөд энд бүтээвэрүүд нь бидний яриа, бичигт илэрч буй хэлбэрээрээ эрэмбэлэгддэг байна.

Ийнхүү бидний сонсож, хэрэглэж буй өгүүлбэрт өнгөн бүтэц ба түүний цаана тухайн хэлээр ярилцагч юуг илэрхийлж буйг мэдэх боломжийг олгогч утгыг хадгалж байдаг гүн бүтэц байдаг аж. Жишээлбэл:

“Дорж Дуламд хайртай.

Дорж Дуламд хайртай юу?

Дулам Доржоор хайрлуулдаг.” гэх гурван өгүүлбэрийн эхнийх нь хүүрнэх, удаах нь асуусан, сүүлийнх нь идэвхигүй хэв бүхий өгүүлбэр байна. Гэвч энэ гурван өгүүлбэр өнгөн бүтцийн хувьд ийнхүү ялгаатай авч сайтар ажиглаваас өөр хоорондоо холбоотой, төстэй байгаа юм. Ийнхүү уг гурван өгүүлбэрийг холбож буй зүйл нь тухайн өгүүлбэрийн гүн бүтэц агаад эдгээр өгүүлбэрийн гүн бүтцэд хайрлах үйлийг эрхлэгч нь Дорж, түүнийг хүлээн авагч нь Дулам, үйлдэж буй үйл нь хайр болох нь илэрхий байна.

¹¹ Ch. Menzel. *Logical form*. In Graig.E (Ed.), *Routledge Encyclopedia of Philosophy*. London and New York: Routledge, 1998.

p 4589

¹² M. Piatelli-Palmarini. *Ever since language and learning: afterthoughts on Piaget-Chomsky debate*. *Cognition*, 1994. p 322

¹³ A. Sandu, & G. Lenci. *Logic and Linguistics in the twentieth*

century. In L. Haaparanta (Ed.), *The development of modern logic*. Oxford University Press, 2009. P 775

“Тэр оройтож боссон тул хичээлээсээ хожигдсон” гэх өгүүлбэрийн гүн бүтцийг

А. Тэр оройтож боссон. Б. Тэр (А шалтгааны улмаас) хичээлээсээ хожигдсон хэмээн илэрхийлж болох юм.

Дээрх тайлбаруудаас харахад гүн бүтцийн тухай санаа нь бодомжийн тухай ойлголттой нэлээд төстэй байгаа юм. Учир нь “Уламжлалт логикт “бодомж” гэдгийн дор янз бүрийн тэмдгийн хэлбэрүүдэд ерөнхий утгатай байх хүүрнэх өгүүлбэрийг ойлгодог. Өөрөөр хэлбэл нэг бодомж нь янз бүрийн үндэстний хэлэнд төдийгүй тухайн нэг үндэстний хэлний хүрээнд янз бүрийн хэлбэрээр илэрч болдог”¹⁴ билээ.

Аливаа өгүүлбэрийн гүн бүтэц ч гэсэн өнгөн бүтэц рүү шилжихдээ ялгаатай хэлбэрээр илэрхийлэгдэж байгаа билээ. Бодомж бүхэн өгүүлбэр байдаг ч өгүүлбэр бүхэн бодомж байх албагүй учир өгүүлбэрийн “бидний сонсож, ярилцаж байгаа хэлбэр” болох өнгөн бүтэц бүр гүн бүтэцтэйгээ адилхан хэлбэртэй байх албагүй хэдий ч гүн бүтцийн илэрхийлэх гэсэн санаа нь хувиргалаар дамжин өнгөн бүтцийг үүсгэсэн байдаг билээ. Мөн тухайн өгүүлбэрийн авианы хэлбэр өнгөн бүтцээр илэрхийлэгдэнэ гэдэг нь “N.Chomsky is linguist.”, “Н.Чомский бол хэл шинжээч.” гэх хоёр өгүүлбэр нь угтаа ижил гүн бүтэцтэй байх бололцоотой гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл тухайн гүн бүтэц нь хийсвэр шинжтэй, тухайн хэлээр хэлэлцэгчийн оюун тархиндаа уг өгүүлбэрээр ямар утгыг илэрхийлэхийг хүсч буйг илэрхийлдэг. Иймээс би англи, монгол, орос зэрэг ямар ч ялгаатай хэлээр

ярьсан байсан “Чомксийг хэл шинжээч” гэсэн утгыг л илэрхийлэхийг зорьсон тул аль ч хэлээр уг санааг илэрхийлсэн илэрхийлэл нь өгүүлбэрийн гүн бүтцийн асуудалтай ямар нэг хэлбэрээр холбогдох нь тодорхой юм. “Бүх” Чомский хэл шинжээч гэх энэ санааг нийтлэгийн квантор ашиглан $\forall xP(x)$ илэрхийлэлээр илэрхийлж болно. Мөн S болох Н.Чомский нь P болох хэл шинжээч гэх шинжийг агуулсан гэж ч ойлгож болох билээ. Хэрэв бид P -н урд үгүйсгэлийн тэмдэг тавих аваас тухайн бодомжийн утга өөрчлөгдөнө. Эндээс бид гүн бүтэц болон логик бүтэц аль аль нь утгазүйтэй холбоотой байгааг онцолж болох юм. Энэ талаар “У.В.О.Куайны орчуулагч” хэмээгдэх Д.Давидсон “логикийн бүтэц болон гүн бүтэц аль аль нь утгазүйн суурь болохыг зорьж буй тул ижил байх боломжтой”¹⁵ хэмээн үзэж байжээ. Өөрөөр хэлбэл жишиг онолын хүрээнд гүн бүтцийг утгазүйн суурь болохыг тодорхойлж байсан тэр байр суурийг Д.Давидсон дэмжсэн гэж үзэж болох юм.

Жишиг онолын хүрээнд утгазүйн бүрэлдэхүүнийг шийдэх бүхий л шийдэл гүн бүтцийн хүрээнд л тодорхойлогдох тул хувиргал нь утгад нөлөөлөхгүй гэсэн санааг илэрхийлж байдаг. Гэтэл логикийн квантор болон холбоос бүхий өгүүлбэрт анализ хийх явцад асуудал тулгарч эхэлсэн байдаг аж.

“Хүн бүр хэн нэгэнд хайртай” гэх өгүүлбэр нь хувиргалын дүрэм ёсоор “Хэн нэгэн хүн бүрээр хайрлагдана” хэмээн хувирах ёстой атал уг өгүүлбэрийн

¹⁴ М.Отгонбаяр. Логик. Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2004. хууд 37

¹⁵ D.Davidson. *Inquiries into truth and interpretation*. Oxford: Clarendon Press, 2001. p 63

илэрхийлж буй санаа нь хоёр ялгаатай утгыг илэрхийлэх болсон аж. Уг асуудлыг шийдэхийн тулд Ж.Лакофф “нийтлэгийн болон оршин байхуйн квантор нь гүн бүтцэд шингэмэл”¹⁶ гэж үзсэн байна. Энэ талаар Гилберт Харман “логикийн квантор болон гүн бүтцийн хооронд тохироо буй эсэхийг эргэцүүлэхэд хүрнэ”¹⁷ хэмээн бичсэн байдагтай дээрх санал тохирч буй юм. Учир нь хэл шинжээчдийн нэрийн хэлцийг тодорхойлогч (determiner) хэмээн нэрлэдэг зарим, бүгд, бүх, тус бүр, цөөн, хэд хэдэн, олон, ихэнхи нь, нэгэн (all, every, each, few, several, many, most, one) гэх мэт ойлголтуудыг хэл шинжлэлийн квантор гэж нэрлэдэг аж. Ийнхүү гүн бүтцийг “логикчлох хандлага” нь аажимдаа өгүүлбэрзүй болон утгазүйн хооронд ялгаа байх шаардлагагүй гэх санааг дэвшүүлсэн “үүсгүүр утгазүйг” бий болоход чухал хувь нэмрээ оруулжээ. Гэвч Р.Харрисийн “Хэл шинжлэлийн дайн”¹⁸ хэмээх номонд өгүүлсэн ёсоор “үүсгүүр утгазүй” нь 1980-аад оны үед “дайнд ялагдсан” билээ.

Мөн квантор бүхий нэрийн хэлц (Quantificational noun phrase) хэмээх томъёоллыг хэл шинжээчид (“Д.Фокс (D.Fox) логикийн хэлбэр дэх суурь утгазүй болон өгүүлбэрзүйн холбоосыг квантор бүхий нэрийн хэлц тайлбарлаж болох юм гэж үзсэн байдаг байна”.)¹⁹ хэрэглэх болсон байдаг аж. Квантор бүхий нэрийн хэлцийн шинж болон “предикат”-ыг ажигласнаар тухайн өгүүлбэрийн

утгыг мэдэх боломжтой аж. Квантор бүхий нэрийн хэлц болон предикат нь мөн үнэний утгыг агуулдаг байна. Жишээлбэл: “1.Залуус намхан, 2.Олон залуу намхан, 3.Залуус бүр намхан” гэсэн өгүүлбэрт буй нэр үгс нь бүгд квантор бүхий нэрийн хэлц аж. Эхний өгүүлбэрт ядаж нэг залуу намхан бол үнэн байхад, удаах өгүүлбэрийн хувьд хэд хэдэн залуу намхан байж байж үнэн болно. Сүүлийн өгүүлбэрийн хувьд залуу л бол намхан байж байж үнэн байх боломжтой юм. Эндээс квантор нь үнэхээр логик хэлбэр болон хэлзүйн хоорондын зууч байхад тохиромжтой байж мэдэх юм. Энэ талаар Д.Давидсон өгүүлбэрийн гүн бүтэц нь логикийн хувьсагчууд, квантор зэргийг агуулаад зогсохгүй “үнэний онол нь (truth theory) гүн хэлзүйгээр илэрхийлэгдэх аваас логик болон хэлзүй нь гар гараасаа атгалцах болно”²⁰ гэж дүгнэсэн байдаг байна.

Нөгөө талаас бид төрөлх хэлэн дэх логик анализ болон гүн бүтцийн тухай тайлбарласан У.В.О.Куаны байрсууринаас хандах аваас Д.Давидсоны тайлбарыг магадлах хэрэгтэй болох болно.²¹

У.В.О.Куайн төрөлх хэлийг логик символ, үнэний функц болон квантороор дамжуулан парафраз хийх явдал нь зарчмын хувьд компьютер програмчлах явдалтай ижил гэжээ. Улмаар логик анализ хийх буюу өгүүлбэрт нуугдмал буй логик бүтцийг олох нь тодорхойгүй,

¹⁶ A. Sandu, & G. Lenci. *Logic and Linguistics in the twentieth century*. In L. Haaparanta (Ed.), *The development of modern logic*. Oxford University Press, 2009. P 776

¹⁷ G. Harman. *Deep structure as logical form*. *Synthese* 21, 1970. p 281

¹⁸ R. Harris. *The Linguistic wars*. Oxford University Press. 1995 номноос үзнэ үү.

¹⁹ R. Hendrick. *Minimalist Syntax*. Oxford: Blackwell, 2003. p 23


²⁰ D. Davidson. *Inquiries into truth and interpretation*. Oxford: Clarendon Press, 2001. p 59

²¹ W. V. O. Quine. *Methodological Reflections on Current Linguistic Theory*. (*Synthese* 21 (3/4):386 – 398), 1970 гэх өгүүлэлийг дэлгэрүүлэн үзнэ үү.

* Гэхдээ ийнхүү тайлбарлаж байгаа нь У.В.О.Куайн логикийг үл тоосон хэрэг биш гэдгийг анхаарна уу.

хий дэмий (idle) явдал гэж үзсэн байна. Учир нь үгэн илэрхийллийг логик томъёолол (formula) руу буулгах явдал нь өөрийн гэсэн техникийн давуу тал, алгоритм бүхий ойлголтоос алхам ухарч буй хэрэг аж.* Нөгөө талаас төрөлх хэл эзэмшигчид гүн бүтэц гэх тодорхой бус (inarticulate) хэлзүйн систем байлаа гэж бодоход бид түүнийг зүйтэй ойлгож тайлбарлаж байгаагаа хэрхэн мэдэх вэ гэх метадологийн шинжтэй асуултыг тэрээр тавьсан байна. За тэгээд зөв яг таг тайлбарлаж байлаа гэхэд Н.Чомскийн чухалчилснаар энгийн тохиромжтой байдалд (simplicity, convenience) анхаарлаа хандуулах аваас гүн бүтцийн объектив байдал нь алдагдана гэж үзсэн байна.

Улмаар тэрээр гүн бүтэц болон логик бүтэц нь эх хэлний өгүүлбэрт парафраз хийдэг ч зорилго нь өөр болохыг онцолсон байна. Хэлзүйч (grammarian) өгүүлбэрээс хэлзүйн модон дүрслэлийн хамгийн бүтээмжтэй замаар үүссэн хэлбэрийг харуулахын тулд парафраз хийдэг байна. Жишээлбэл Дорж номоо авав ($[_s[_{NP}\text{Дорж}][_v[_{NP}\text{номоо}]]\text{авав.}])$ гэхийг



Схем ii

хэмээн модон дүрслэлээр илэрхийлж болно. Энэхүү гүн бүтэц нь тухайн өгүүлбэрийн утгазүйн талыг бас хариуцаж байгаа билээ. Гэтэл нөгөө талаас логикч өгүүлбэрийг логик парадокс болон алдааг

арилгахын тулд хэлбэрт оруулдаг байна. Ийнхүү гүн бүтэц хийгээд, логик хэлбэр хоёр нь хоёр өөр зорилгын хүрээнд хийгдэж буй тул ялгаатай аж.

Өөрөөр хэлбэл логик тооцооллын тулд төрөлх хэлийг логик хэлбэрээр илэрхийлдэг бол гүн бүтэц нь утгазүйн төлөөллийг агуулсан өгүүлбэрзүйн түвшний илэрхийлэл аж. Цаашилбал логик хэлбэр нь “гадаад” (түүний логик алдааг илрүүлэх гэх мэт) сэдэлтэй байхад өгүүлбэрийн гүн бүтэц нь оюун тархины бүрэлдэхүүнийг илрүүлэх гэсэн “дотоод” сэдэлтэй байна. Энд хэрэглэж буй гадаад гэх үгэнд бихеворист утга оноож буй бол дотоод гэх үгэнд менталист санаа байгааг анхаарна уу.

Тэгэхээр хэрэв бид У.В.О.Куайны санааг дагах аваас логик хэлбэр болон гүн бүтэц нь парафраз хийдгээрээ төсөөтэй ч зорилгын хувьд ялгаатай, шууд адилтгаж боломгүй ойлголтууд гэж дүгнэж болох юм.

Энд Д.Давидсоны санааг дэмжин логик квантороор дамжуулан гүн бүтцийн тухай ойлголтыг логик хэлбэр болохыг баталж болох биш үү? гэсэн асуулт үлдэж байна. Гэхдээ Ц.Гомбосүрэнгийн “Бодомжийн логик бүтцийн асуудалд холбогдох философи зарим эргэцүүлэл” гэх өгүүлэл дэх “бүх”, “зарим”, “нэг ч” гэх зэрэг логик квантор нь “тухайн бодомждоо логик тогтворт санаатай биш, харин хэлзүйн утгатай байдаг”²² гэх дүгнэлтэнд үнэмших аваас логик кванторт ийнхүү холбоос болох бололцоо хомс болж байгаа юм.

²² Ц.Гомбосүрэн. “Бодомжийн логик бүтцийн асуудалд холбогдох философи зарим эргэцүүлэл” *Философи, Шашин судлал-ХIII*, УБ. X. 15

Ийнхүү гүн бүтэц нь логик хэлбэр мөн үү гэх асуултанд эдгээр нь төстэй шинжтэй ч шууд адилтгаж боломгүй ойлголтууд аж гэх хариултыг өгснөөр өгүүллээ өндөрлөө.

НОМ ЗҮЙ

1. Ц. Гомбосүрэн. “Бодомжийн логик бүтцийн асуудалд холбогдох философи зарим эргэцүүлэл” Философи, Шашин судлал-ХIII
2. М.Отгонбаяр. Логик. Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2004
3. К.Поппер. “Бие оюун ухаан хоёрын харилцан үйлчлэлийн асуудал хийгээд мэдлэг. Орч: М.Отгонбаяр. Эрх чөлөө ба философи.(III). Улаанбаатар, 1998.
4. N. Chomsky. Aspects of theory of syntax. Massachusetts: MIT press, 1965.
5. D. Davidson. Inquiries into truth and interpretation. Oxford: Clarendon Press, 2001. p
6. L.T.F. Gamut. Logic language and meaning: Volume 2 Intensional logic and logicagal grammar. Chicago: University of Chicago press, 1991.
7. G. Harman. Deep structure as logical form. Synthese 21, 1970.
8. R. Hendrick . Minimalist Syntax. Oxford: Blackwell, 2003
9. J. McGilvray (ed). The Cambridge Companion to Chomsky. Cambridge University Press, 2005.
10. Ch. Menzel. Logical form. In Graig.E (Ed.), Routledge Encyclopedia of Philosophy. London and New York: Routledge, 1998. p 4589
11. W. V. O. Quine. Methodological Reflections on Current Linguistic Theory. (Synthese 21 (3/4):386 – 398), 1970
12. A. Sandu, & G. Lenci, G. Logic and Linguistics in the twentieth century. In L. Haaparanta (Ed.), The development of modern logic. Oxford University Press, 2009.
13. J. Searle. Chomsky’s Revolution in Linguistics, Retrieved from The Noam Chomsky, June 29, 1972. url: <http://www.chomsky.info/onchomsky/19720629.htm>
14. J. C. Stanley (n.d.). Logical Form, Origins of. Retrieved from The MIT Encyclopedia of the Cognitive Sciences url: <http://ai.ato.ms/MITECS/Entry/stanley2.html>
15. M. Piatelli-Palmarini. Ever since language and learning:afterthoughts on Piaget-Chomsky debate. Cognition, 1994. p 322